



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/76/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр

орлон гүйцэтгэгч : Г.Заяа

Утас:92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК

Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг

Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	15
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	15
4.2.1 Залруулсан алдаа.....	15
4.2.2 Төлбөрийн акт.....	16
4.2.3 Албан шаардлага	16
4.2.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУ	Монгол улс

1.Аудитын санал дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улнастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.22 № 1302/БТ

танай _____ -ны № _____ -т

ТҮДЭВТЭЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.БЯМБАДОРЖ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013022073

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>106,291.73</u>	<u>91,093.44</u>
33	АВЛАГА	14,058.67	10,544.28
335	Бусад авлага	14,058.67	10,544.28
3351	Байгууллагаас авах авлага	10,043.59	1,279.73
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,015.08	9,264.55
35	БАРАА МАТЕРИАЛ	92,233.06	80,549.15
351	Түүхий эд материал	14,248.94	12,946.08
35110	Тусгай зориулалттай материал	14,200.94	12,570.83
35130	Эм боох материал	48.00	375.25
354	Хангамжийн материал	77,984.12	67,603.07
35410	Бичиг хэргийн материал	6,443.91	7,354.21
35420	Аж ахуйн материал	3,083.30	3,419.61
35430	Сэлбэг хэрэгсэл	139.70	-
35440	Түлш, шатах тослох материал	2,330.00	-
35450	Барилгын засварын материал	4,543.41	4,294.65
35460	Хүнсний материал	15,108.85	3,651.95
35470	Бусад хангамжийн материал	46,334.94	48,882.64
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,651,051.88</u>	<u>1,551,520.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,651,051.88	1,551,520.84
392	Биет хөрөнгө	1,580,805.88	1,481,274.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,537,932.57	1,537,932.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	(149,110.26)	(218,820.29)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,150.00	14,150.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(12,016.67)	(14,150.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	187,158.99	188,008.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	(157,675.08)	(168,793.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	182,656.71	182,956.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	(67,427.17)	(84,979.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,101.88	9,101.88
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,822.43)	(8,989.10)
39217	Ном	44,857.34	44,857.34
393	Биет бус хөрөнгө	70,246.00	70,246.00
39301	Програм хангамж	1,650.00	1,650.00
39303	Бусад биет бус хөрөнгө	69,546.00	69,546.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(950.00)	(950.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,757,343.61</u>	<u>1,642,614.28</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,674.30</u>	<u>2,871.10</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,674.30	2,871.10
413	Өглөг	1,674.30	2,871.10
4136	Бусад өглөг	1,674.30	2,871.10
41361	Байгууллагад төлөх өглөг	1,674.30	2,871.10

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,755,669.31</u>	<u>1,639,743.18</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,755,669.31	1,639,743.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,280,767.38	1,280,767.38
51101	Өмч: - төрийн	1,280,767.38	1,280,767.38
512	Хуримтлагдсан үр дүн	69,191.08	(46,735.05)
51210	Өмнөх үеийн үр дүн	69,191.08	69,191.08
51220	Тайлант үеийн үр дүн	-	(115,926.13)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	405,710.85	405,710.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,757,343.61</u>	<u>1,642,614.28</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	943,699.53	941,355.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,439.73	157.20
120	Нийтлэг татварын бус орлого	36,439.73	157.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,439.73	157.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	36,439.73	157.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	907,259.80	941,198.05
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	682,355.40	714,868.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	682,355.40	714,868.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,463.60	14,811.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,067.30
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,463.60	5,744.16
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	223,440.80	211,517.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	223,440.80	211,517.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	991,560.93	1,057,281.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	991,560.93	1,057,281.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	936,173.75	1,022,672.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	526,382.81	555,879.83
210101	Үндсэн цалин	348,818.42	378,429.29
210102	Нэмэгдэл	144,557.59	133,798.75
210104	Урамшуулал	33,006.79	43,651.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,345.87	68,251.56
210201	Тэтгэврийн даатгал	44,633.22	43,952.94
210202	Тэтгэмжийн даатгал	5,189.36	5,142.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,177.05	4,478.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,037.87	991.80
210205	Эрүүл мэндийн даатгал	10,308.36	13,685.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	194,174.31	220,713.88

Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	2,435.68	2,818.55
210302	Түлш, халаалт	191,599.63	217,845.33
210303	Цэвэр, бохир ус	139.00	50.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,481.36	32,949.92
210401	Бичиг хэрэг	1,202.62	966.38
210402	Тээвэр, шатахуун	3,094.26	3,355.35
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,062.40	-
210404	Ном, хэвлэл	61.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,021.08	28,628.19
2105	Нормативт зардал	29,648.38	40,095.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	579.55	1,482.76
210502	Хоол, хүнс	29,068.83	38,612.28
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	364.59
210604	Урсгал засвар	-	364.59
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	742.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	592.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,399.02	104,418.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	208.30	4.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,790.98	3,733.11
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,399.75	100,681.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,387.17	34,608.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,437.70	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,937.70	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,949.47	34,608.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,949.47	34,608.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(47,861.40)	(115,926.13)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,505.98	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,505.98	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,505.98)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(49,367.38)	(115,926.13)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,280,767.38	405,710.85	69,191.08	1,755,669.31
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,280,767.38	405,710.85	69,191.08	1,755,669.31
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,280,767.38	405,710.85	69,191.08	1,755,669.31
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(116,320.86)	(116,320.86)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,280,767.38	405,710.85	(47,129.78)	1,639,348.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	907,259.80	941,198.05
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	907,259.80	941,198.05
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	682,355.40	714,868.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	682,355.40	714,868.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,463.60	14,811.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,067.30
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,463.60	5,744.16
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	223,440.80	211,517.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	223,440.80	211,517.90
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	902,289.80	940,048.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	902,289.80	940,048.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	840,802.63	882,793.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	526,382.81	555,879.83
210101	Үндсэн цалин	348,818.42	362,112.49
210102	Нэмэгдэл	144,557.59	153,261.50
210104	Урамшуулал	33,006.79	40,505.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,345.87	70,424.38
210201	Тэтгэврийн даатгал	44,633.22	43,729.78
210202	Тэтгэмжийн даатгал	5,189.36	9,260.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,177.05	4,649.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,037.87	1,162.30
210205	Эрүүл мэндийн даатгал	10,308.36	11,622.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,667.45	210,586.02

210301	Гэрэл, цахилгаан	3,667.68	3,964.55
210302	Түлш, халаалт	202,860.78	206,571.47
210303	Цэвэр, бохир ус	139.00	50.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,919.86	9,583.43
210401	Бичиг хэрэг	1,727.40	1,172.28
210402	Тээвэр, шатахуун	3,094.26	3,557.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,062.40	429.60
210404	Ном, хэвлэл	61.00	2,354.26
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,934.80	2,069.69
2105	Нормативт зардал	31,253.63	26,262.79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	408.00	999.65
210502	Хоол, хүнс	30,845.63	24,663.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	863.90
210604	Урсгал засвар	-	863.90
2107	Томилолт, зочны зардал	-	1,400.00
210702	Дотоод албан томилолт	-	1,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	742.00	800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	592.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,491.00	6,993.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,491.00	6,993.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,487.17	57,254.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,537.70	22,646.30
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,037.70	13,489.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	9,067.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00	90.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,949.47	34,608.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,949.47	34,608.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,970.00</u>	<u>1,150.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,970.00	1,150.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,970.00	1,150.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,970.00	1,150.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,970.00	1,150.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(4,970.00)</u>	<u>(1,150.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	960,049.70	891,778.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	960,049.70	891,778.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	944,660.70	878,199.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	581,570.40	555,879.83
210101	Үндсэн цалин	407,141.00	362,112.49
210102	Нэмэгдэл	145,721.60	153,261.50
210104	Урамшуулал	28,707.80	40,505.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,511.90	70,424.38
210201	Тэтгэврийн даатгал	55,249.20	43,729.78
210202	Тэтгэмжийн даатгал	5,815.70	9,260.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,652.60	4,649.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,163.10	1,162.30
210205	Эрүүл мэндийн даатгал	11,631.30	11,622.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	236,517.90	210,586.02
210301	Гэрэл, цахилгаан	10,387.80	3,964.55
210302	Түлш, халаалт	225,232.90	206,571.47
210303	Цэвэр, бохир ус	897.20	50.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,739.70	8,487.27
210401	Бичиг хэрэг	1,067.10	991.98
210402	Тээвэр, шатахуун	4,674.30	3,557.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800.00	429.60
210404	Ном, хэвлэл	1,600.70	1,438.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	597.60	2,069.69
2105	Нормативт зардал	32,185.10	26,262.79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000.00	999.65
210502	Хоол, хүнс	30,096.60	24,663.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,088.50	600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000.00	863.90
210604	Урсгал засвар	1,000.00	863.90
2107	Томилолт, зочны зардал	1,494.00	1,400.00
210702	Дотоод албан томилолт	1,494.00	1,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800.00	800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800.00	800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,841.70	3,495.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,841.70	3,495.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,389.00	13,579.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,389.00	13,579.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,889.00	13,489.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00	90.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	959,570.40	926,386.60
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	722,052.50	714,868.70
131001	Улсын төсвөөс санхүүжих	722,052.50	714,868.70
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	237,517.90	211,517.90
132001	Орон нутгийн төсвөөс	237,517.90	211,517.90

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,811.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,811.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,744.16
2104	Хангамж, бараа материалын зардал	1,096.16
210401	Бичиг хэрэг	180.30
210404	Ном, хэвлэл	915.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,648.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,648.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,067.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,067.30
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,067.30
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,811.45
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,811.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,067.30
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,744.16

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 13-ны өдрийн №1/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургууль нь бага дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү үйл ажиллагаандаа дагаж мөрддөг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн 959.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 14.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 75 хувь буюу 10.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	14,058.67	10,544.28	(3,514.38)
Бараа материал	92,233.06	80,549.15	(11,683.91)
Үндсэн хөрөнгө	1,651,051.88	1,551,520.84	(99,531.04)
Нийт хөрөнгө	1,757,343.61	1,642,614.28	(114,729.33)
Өр төлбөр	1,674.30	2,871.10	1,196.80
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,755,669.31	1,639,743.18	(115,926.13)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,757,343.61	1,642,614.28	(114,729.33)

Авлага дансны үлдэгдэл 3.5 сая төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлага 8.8 саяаар буурч, хувь хүмүүсээс авах авлага 5.3 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 11.7 сая төгрөгөөр буурсан нь 73.5 сая төгрөгийг бараа материал худалдан авахад зарцуулж, хандиваар 0.16 сая төгрөгийн эм боох материал ирсэн ба 79.4 сая төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 99.5 сая төгрөгөөр буурсан нь 1.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авалт, 100.7 сая төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1.2 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөгөөр өссөнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 115.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 237.5 сая, улсын төсвөөс 722.5 сая, нийт 960.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 960.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 714.9 сая, орон нутгийн төсвөөс 211.5 сая, нийт 926.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 891.8 сая төгрөгийг зарцуулж, 34.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

2021 онд нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 9.1 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5.7 сая, нийт 14.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 5.7 сая, хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 9.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Жилийн эцсийн тооллогоор хүнсний материал /мах/ дутагдсаныг авлагаар тусган залруулсан.

3.8 Аудитын гол асуудал

Шилэн дансны мэдээллийг хууль, журмын дагуу үнэн зөв мэдээлээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 онд нийт 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 7 мэдээллийг ил тод байршуулаагүй, 16 мэдээллийг хугацаа хоцроож

мэдээлсэн байна. Цалингаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий ажил гүйлгээний зардал хэсгийг буруу мэдээлсэн, хөрөнгө оруулалт, худалдан авалтын 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг өссөн дүнгээр мэдээлээгүй, хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлдэггүй зэрэг зөрчил илэрлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд халаалтын хөлсийг бараа материалын дансаар дамжуулсан, цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй гүйлгээ хийгдсэн гэсэн зөвлөмжийн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2020 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан биет бус хөрөнгөд бүртгэлтэй Си Ти Эс санхүүгийн программын ашиглалтын давуу болон сул талыг одоогийн программтай харьцуулан дүгнэлт гаргаж, дээд шатны байгууллагад хандан шийдвэрлэж зохих арга хэмжээг авч ажилласан эсэхийг шалгах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсарын үеийн аудитад хамрагдаагүй байна.

4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 45.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14.2 сая төгрөгийн алдааг залруулж, 7.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 23.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 6.2 сая, үр дүнгийн тайланд 8.0 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

- ✓ *1.3 сая төгрөгийн түлш халаалтын зардлыг мөнгөн сууриар бүргэж, авлагыг дутуу бүртгэсэн.*
- ✓ *8.0 сая төгрөгийн цалин, ажил олгоогчийн шимтгэлийг шилжүүлэн бүртгэсэн.*
- ✓ *Бараа материалын үлдэгдэлд байх хонины махнаас жилийн эцэсийн тооллогоор 4.9 сая төгрөг өртөг бүхий мах дутагдсаныг нярав хүлээн зөвшөөрч төлөх бичиг үйлдсэнийг бараа материалын үлдэгдлээр бүртгэсэн.*

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ *УСНББОУС-15 Толилуулга ба тодруулга, УСНББОУС 2 Мөнгөн гүйлгээний тайлан, УСНББОУС 12 Бараа материал стандартуудтай нийцээгүй, үнэн зөв байх, оршин байх зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул алдааг залруулсан.*

4.2.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

- ✓ Засгийн газрын 382 дугаар тогтоолын 1-р хавсралтыг зөрчин төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлийг 0.77 сая төгрөгөөр зөрүүтэй тооцоолж олгосон.
- ✓ Ажилчдын ээлжийн амралтын цалингаас 6.7 сая төгрөгийн татвар, НДШ дутуу суутгасан.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.3, 4.2.3.4 заалтуудыг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

4.2.3 Албан шаардлага

1.1. Илрүүлэлт:

- ✓ Төсвийн 0.6 сая төгрөгийн хөрөнгөөр ажилтнуудад нормын хувцас худалдан авч олгосон.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 43 дугаар тогтоолыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ Түүвэрт хамрагдсан ажил гүйлгээнээс 23.0 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй.

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургууль	8	45.3	3	14.2	2	7.5	1	0.6	1	23.0
Дүн		8	45.3	3	14.2	2	7.5	1	0.6	1	23.0